



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/352

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн 87 дугаар сургуулийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,101,369.90 (найман сая нэг зуун нэг мянга гурван зуун жаран есөн төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 87 дугаар сургууль (Б.Энхбат)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй нийт 8,101,369.90 (найман сая нэг зуун нэг мянга гурван зуун жаран есөн төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Баянзүрх дүүргийн 87 дугаар сургууль (Б.Энхбат)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001005



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/352 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 87 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгуулагын үнийн санал	НӨХГ мэргэжилтний үнийн санал	ЭБХХК-ын хурлын шийдвэр
Номын фонд													
1	Сурах бичиг	5-12	ш	4968		7,149,496.9		7,149,496.9					
2	Хүүхдийн уран зохиолын ном	6-28	ш	139		951,873.0		951,873.0					
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					8,101,369.9	-	8,101,369.9					
	Үүнээс Худалдах хөрөнгө												
	Актлах хөрөнгө												
	Татан төвлөрүүлэх хөрөнгө												
	Худалдсанаас олох орлого												
	НӨХГ-т төвлөрүүлэх 30%												